



**Банкны тухай хуульд 2021 оны 1 дүгээр сарын 29-ний
өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн тухай**

Агуулга

I. “Системд нөлөө бүхий банк”-ыг тодорхойлох шинэ үзүүлэлт	3
II. “Системийн банк”: Хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөх, нэг хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээнд тавигдах хязгаарлалт.....	4
III. Банкууд төлөвлөгөө боловсруулж батлуулна	7
IV. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахад МБ-наас зөвшөөрөл авах	10
V. Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)	12
VI. “Системийн банк”-ны хувь нийлүүлсэн хөрөнгөд тавих шаардлага.	13
VII. Төлбөр барагдуулах дараалал.....	14
VIII. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид хамаарах шаардлага	16
IX. Бусдын нэрийг ашиглан банкны хувьцааг эзэмшихийг хориглох	17
X. Банкны хувьцааг барьцаалахыг хориглох	18
ДҮГНЭЛТ	18

Банкны тухай хуульд 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн тухай

2010 онд батлагдсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр УИХ-аас баталсан ("**Хууль**"). Тус Хуулийн хамт уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль ("**Дагаж Мөрдөх Хууль**", Хуультай хамт цаашид "**Нэмэлт, Өөрчлөлт**" гэх) батлагдсан. Нэмэлт, Өөрчлөлт батлагдсанаар манай улсын банкны салбар төдийгүй үнэт цаасны зах зээлд томоохон өөрчлөлтийг бий болгохоор байна.

Нэмэлт, Өөрчлөлтийн¹ зарим гол агуулгыг үүгээр хүргэж байна:

I. “Системд нөлөө бүхий банк”-ыг тодорхойлох шинэ үзүүлэлт

Өмнөх хуулиар “*системд нөлөө бүхий банк*” гэж сүүлийн 6 сарын турш банкны системийн нийт активын 5 болон түүнээс дээш хувийг эзэлж байгаа банкныг тооцож ирсэн (“*системийн банк*”). Харин Нэмэлт, Өөрчлөлтөд зааснаар, аливаа банкныг “системийн банк” эсэхийг олон улсын Базелийн Хорооны стандартын дагуу Монголбанкнаас (“**МБ**”) тогтоох бөгөөд үүнд, банкны нийт хөрөнгө, нийт өр төлбөр, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дүнд эзлэх хувь, үндсэн үйл ажиллагаа, харилцагчдын тоо, санхүүгийн тогтолцоон дахь хамаарал зэргийг харгалзан үзэхээр тусгасан байна.

¹ 2018 онд батлагдсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаарх мэдээллийг дараах хаягаар үзэх боломжтой: www.khanlex.mn/wp-content/uploads/2020/12/BankingLaw-Aug-2018.pdf.

II. “Системийн банк”: Хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөх, нэг хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээнд тавигдах хязгаарлалт

Нэмэлт, Өөрчлөлтийн дагуу бүх арилжааны банк дараах хоёр шаардлагыг ханган ажиллахаар заасан байна. Үүнд:

1.1. Үндсэн Шаардлага 1 – хуулийн этгээдийн хэлбэрийг өөрчлөх:

2022 оны 6 дугаар сарын 30-ны дотор, МБ-наас “системийн банк” гэж тогтоосон банкнууд “нээлттэй хувьцаат компани” хэлбэртэй болсон байх ёстой (“**нээлттэй ХК**”). Үүний дагуу системийн банкнууд 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө тодорхой тооны хувьцаагаа нийтэд санал болгосон байх шаардлагатай. Харин бусад “системийн бус” банкны хувьд “хаалттай хувьцаат компани”-ийн хэлбэртэй болсон байхыг шаардаж буй бөгөөд системийн бус банк өөрийн сонголтоор “системийн банк”-ны адил нээлттэй ХК болох сонголттой.²

1.2. Үндсэн Шаардлага 2 – банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах:

² Өнөөдрийн байдлаар манай улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны 12 банк бүгд “хязгаарлагдмал хариуцлагатай компани” юм. Эдгээрийн ихэнхийн хувьцааны өмчлөл цөөн хэдэн хувьцаа эзэмшигчдэд төвлөрсөн байдаг. Мөн, “хаалттай ХК” ба “нээлттэй ХК” нь дараах ялгаатай:

- "нээлттэй ХК"-ийн хувьцаа нь хөрөнгийн биржид бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагдана,
- "хаалттай ХК"-ийн хувьцаа нь хөрөнгийн биржид бүртгэгдэж, арилжаалагдахгүй, харин үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, хаалттай хүрээнд арилжаалагдана.

2023 оны 12 дугаар сарын 31-ний дотор, аливаа хувьцаа эзэмшигчийн дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцааны хэмжээг тухайн банкны нийт гаргасан хувьцааны хорин (20) хувиас хэтрэхээргүй байхаар тогтоосон байна. Иймд 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, арилжааны банк тав (5)-аас доошгүй хувьцаа эзэмшигчтэй болно³.

Дээрх хоёр шаардлага нь Нэмэлт, Өөрчлөлтөд шинээр тусгасан зохицуулалтууд дундаас хамгийн ач холбогдолтой нь юм (“**Үндсэн Шаардлагууд**”).

Дагаж Мөрдөх Хуулийн дагуу, 2021 оны 6 дугаар сарын 30-ны дотор системийн банкнууд Үндсэн Шаардлагуудыг хэрхэн хангах тухай төлөвлөгөөг МБ болон Санхүүгийн Зохицуулах Хороонд (“СЗХ”)⁴ хүргүүлнэ (“**Төлөвлөгөө**”). (“**III. Банкууд төлөвлөгөө боловсруулж батлуулна**” тухай хэсгийг дор үзнэ үү).

Үндсэн Шаардлагуудыг хангахгүйд хүрвэл МБ-ны зүгээс тухайн банкны хувьд урьдчилан сэргийлэх арга хэмжээ, нөхцөлт удирдлага, бүтцийн өөрчлөлт зэрэг албадлагын арга хэмжээ, эсхүл хуульд заасан бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр Дагаж Мөрдөх Хуульд заасан.

Нэмэлт, Өөрчлөлтөд дээрх шаардлагуудыг хэрхэн хэрэгжүүлэх тухай дэлгэрэнгүй зохицуулаагүй байна. Дагаж Мөрдөх Хуульд зааснаар МБ, СЗХ Төлөвлөгөөг

³ Энэ шаардлага дараах банкинд үл хамаарна: Монгол Улсын Хөгжлийн Банк, бүтцийн өөрчлөлт хийж буй, мөн 2018 онд батлагдсан Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн дагуу төрөөс дахин хөрөнгөжүүлж буй банкны төрийн мэдлийн хувьцаанд (Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн талаарх мэдээллийг дараах хаягаар үзэх боломжтой: www.khanlex.mn/wp-content/uploads/2020/12/BankingLaw-Aug-2018.pdf).

⁴ СЗХ нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллага юм.

боловсруулах, хянах журмыг зохицуулах “түр журмыг” (“**Журам**”) хамтран батална. (“**III. Банкууд төлөвлөгөө боловсруулж батлуулна**” тухай хэсгийг дор үзнэ үү).

III. Банкууд төлөвлөгөө боловсруулж батлуулна

Системийн банкнууд Үндсэн Шаардлагуудыг хэрхэн биелүүлэх тухай Төлөвлөгөөг боловсруулж, батлуулах үүрэг хүлээжээ.

Дээр дурдсанаар холбогдох Журмыг МБ, СЗХ хамтран батална. Тус Журмаар Төлөвлөгөөг боловсруулах, хянах журмыг зохицуулна гэж ойлгож байна. Одоогоор Журмыг батлаагүй байгаа бөгөөд Журмын төслийг МБ-наас боловсруулж олон нийтээс санал авахаар 2021 оны 2 дугаар сард нийтэлсэн байна⁵.

Журмын төслийн дагуу, Төлөвлөгөөнд Үндсэн Шаардлага 1-г дараах байдлаар үе шаттай хангах шаардлагатай. Үүнд: (i) 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор банкны нийт хувьцааны 10 хувиас багагүй хувьцааг нийтэд санал болгон анх удаа гаргаж нээлттэй ХК болох, (ii) 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор нэмж 10 хувиас багагүй хувьцааг нэмж гарган нийтэд арилжаалах. Үүнээс банк нь хувьцааг олон нийтэд хоёр удаа санал болгохын оронд, нийт хувьцааны 20 хувийг нэг удаа нийтэд санал болгон худалдах боломжтой гэж ойлгогдож байна. Нөгөө талаас, нийт хувьцааны 20 (10+10) хувиас доошгүй хувьцааг заавал нийтэд санал болгох шаардлагатай, эсхүл "стратегийн хөрөнгө оруулагч(ид)" эдгээр хувьцааг худалдаж авч болох эсэх нь тодорхойгүй байна (Үндсэн Шаардлага 2-н дагуу нэг хувьцаа эзэмшигч дээд тал нь хувьцааны 20 хувийг эзэмших боломжтой).

⁵ <https://www.mongolbank.mn/documents/Reg%20draft.pdf>

Мөн Төлөвлөгөөнд хувьцааг олон нийтэд санал болгох арга хэлбэр, хугацаа, санал болгох хувьцааны үнийн төсөөлөл, боломжит хөрөнгө оруулагчдын тандан судалгаа, нийт татах хөрөнгө оруулалтын хэмжээ, жижиг хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлэх хувьцааны тоо зэргийг дэлгэрэнгүй тусгахаар заасан байна.

Журмын төсөлд Үндсэн Шаардлага 2-г хэрэгжүүлэх арга хэлбэр, хугацаа (2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор), боломжит хөрөнгө оруулагчдын тандан судалгаа зэргийг Төлөвлөгөөнд мөн тусгахаар заасан байна. Төлөвлөгөөнд мөн Үндсэн Шаардлагуудыг хангасны дараагаар (өөрөөр хэлбэл, 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн дараа) банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд хэрхэн өөрчлөлт орох талаарх тооцоо, мэдээллийг тусгана⁶.

Төлөвлөгөөг батлуулахаар 2021 оны 7 дугаар сарын 01-ний дотор МБ, СЗХ-нд хүргүүлэх ба МБ, СЗХ-ноос банкнаас ирүүлсэн Төлөвлөгөөг “хэрэгжүүлэх боломжгүй, эсхүл үндэслэлгүй” эсхүл Журамтай “нийцээгүй” гэж үзвэл Төлөвлөгөөг өөрчлөхийг шаардаж болно.

Дээр дурдсаны дагуу Нэмэлт, Өөрчлөлтийг хэрэгжүүлэх үүднээс Төлөвлөгөөнд нэлээд хэдэн чухал асуудлыг тусгахаар байна. Жишээлбэл, Журмын төсөлд зааснаар Төлөвлөгөөнд (i) нийт хувьцааны 10 хувиас багагүй хувьцааг нийтэд санал болгох замаар банкныг нээлттэй ХК болгон өөрчлөх байгуулах (Үндсэн Шаардлага 1) болон (ii) одоогийн хувьцааны өмчлөлийн төвлөрлийг банкны нийт гаргасан

⁶ Бид Журмын төслийг 2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр үзсэн болно.

хувьцааны хорин (20) хувиас хэтрэхээргүй байх хэмжээнд хүргэх (Үндсэн Шаардлага 2) гэсэн хоёр шаардлагыг хэрхэн хангахыг тусгахаар байна.

Иймд МБ, СЗХ-наас баталснаар Төлөвлөгөө нь IPO гаргах, нэмж хувьцаа гаргах үеийн үнэт цаасны танилцуулга бэлтгэх (Үндсэн Шаардлага 1), одоо эзэмшиж буй хувьцааг худалдах, нэмэлт хөрөнгө оруулалт татахад (Үндсэн Шаардлага 2) үндсэн баримт бичиг болох зэргээр банкнуудын ойрын хэдэн жилийн стратегийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэх баримт бичиг мөн байна.

Дээр дурдсанаар Үндсэн Шаардлагуудыг хангахгүйд хүрвэл МБ, СЗХ-ны зүгээс тухайн банкны хувьд урьдчилан сэргийлэх арга хэмжээ, нөхцөлт удирдлага, бүтцийн өөрчлөлт зэрэг албадлагын арга хэмжээ, эсхүл хуульд заасан бусад арга хэмжээг авна.

Журмаас гадна МБ, СЗХ-ноос Үндсэн Шаардлага 1-н дагуу банкнууд хувьцаагаа хөрөнгийн биржэд бүртгүүлэх шаардлага, үйл явцыг зохицуулах журмыг боловсруулж батална гэж ойлгож байна (одоогийн журмуудын зохицуулалт нь банкнуудад тэр бүр тохиромжгүй).

2021 оны 6 дугаар сарын 30-ны дотор банкнууд өөрсдийн Төлөвлөгөөг боловсруулж МБ, СЗХ-нд хүргүүлэх боломжийг хангах үүднээс Журмыг ойрын хугацаанд батлана гэсэн хүлээлттэй байна.

IV. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахад МБ-наас зөвшөөрөл авах

Банкны хувьцаатай холбоотой дараах хэлцэл хийх тухай бүрт МБ-нд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авна:

- (i) аливаа этгээд шинээр “нөлөө бүхий” хувьцаа эзэмшигч болох (өөрөөр хэлбэл, банкны хувьцааны тав ба түүнээс дээш хувийг дангаар эзэмших, эсхүл банкны бодлого, шийдвэр болон удирдлагад нөлөөлөхүйц хувьцаа эзэмшигч болох),
- (ii) “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч”-ийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт орох,
- (iii) банкны нийт хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт орох,
- (iv) шинээр хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах.

Мөн гадаадын хөрөнгө оруулалттай банкны хувьцааг худалдан авах тохиолдолд МБ-аас урьдчилан зөвшөөрөл авна.⁷

МБ-нд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авахтай холбогдох журмыг МБ, СЗХ хамтран батлахаар Хуульд заасан байна (өмнө нь уг журмыг МБ-наас батлан мөрдүүлж байсан). Уг журмаар банкууд нээлттэй ХК болж, улмаар хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалахад МБ-ны хяналт тавих, зөвшөөрөл өгөх үйл явц хэрхэн хэрэгжихийг тодорхой болгох нь чухал юм. Хуульд МБ-наас хяналт тавих, зөвшөөрөл өгөх хувьцаатай холбоотой хэлцлүүдийн цар хүрээ нэлээд өргөн байгааг дурдах нь зүйтэй. Жишээлбэл, банкны хувьцааг нээлттэй, чөлөөтэй арилжаалахтай

⁷ Гадаадын хөрөнгө оруулалттай банк гэж тухайн банкны нийт хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшдэг банкныг ойлгоно.

холбоотой зарим гүйлгээнд урьдчилсан зөвшөөрөл авахын тулд биржийн бус (багцын) арилжаа хэлбэрээр хийх шаардлагатай болж магадгүй юм. Түүнчлэн банкны “нөлөө бүхий” хувьцаа эзэмшигч өөрийн хувьцааг банкинд буцаан худалдаж болох эсэх, өөрөөр хэлбэл, банкинд эзэмшиж буй хувьцааны хэмжээгээ бууруулах, эсхүл хувьцаагаа бүхэлд нь худалдах хүсэлтэй байгаа нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааг банк буцаан худалдаж авч болох эсэх нь тодорхойгүй байна.

Мөн Хуулийн 36 дугаар зүйлийн 36.11 дэх хэсэгт хувьцааг бусдад шилжүүлэх, эсхүл худалдахтай холбоотой аливаа хэлцэлд МБ-наас зөвшөөрөл авахыг шаардаж буй мэт ойлгогдож байна. Хэрэв тийм бол энэхүү шаардлага нь өдөр тутмын хувьцааны арилжаа хийхэд хамаарахаар байгаа ба энэ нь банк нээлттэй хувьцаат компани болох, улмаар хувьцаагаа нийтэд, чөлөөтэй арилжих гэсэн Нэмэлт, Өөрчлөлтийн үзэл санаанд нийцээгүйгээс гадна практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байж болох юм.

Дээр заасан МБ-ны зөвшөөрлийг аваагүй тохиолдолд тухайн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцаа нь саналын эрхгүй, ногдол ашиг авах эрхгүй болно гэсэн үр дагавар үүсэхээр байна. Улмаар МБ тухайн хувьцааг тухайн банкны өөрийн хөрөнгөөс хасч тооцох бөгөөд тухайн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь ийнхүү хассанаас хойш 30 хоногт багтаан бусдад худалдах, шилжүүлэх үүрэгтэй.

Ерөнхийдөө МБ-наас хяналт, зөвшөөрлийн чиг үүргээ практикт буюу нээлттэй ХК-ийн хувьцааны арилжааны үед хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхой зохицуулах шаардлагатай гэж үзэж байна.

V. Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)

- ТУЗ нь есөөс доошгүй гишүүнтэй байна.

Өмнөх зохицуулалтаар, системийн бус банкууд таваас доошгүй гишүүнтэй байхыг зөвшөөрч байсан. Нэмэлт, Өөрчлөлтийн дагуу, хэмжээнээс үл хамааран бүх банкны ТУЗ есөөс доошгүй гишүүнтэй байх шаардлагатай болж байна.

- ТУЗ-ийн нийт гишүүдийн гурваас доошгүй нь хараат бус гишүүн байна.

Өмнөх зохицуулалтаар, системийн бус банк ТУЗ-ийн нэг хараат бус гишүүнтэй байхыг зөвшөөрч байсан. Нэмэлт, Өөрчлөлтийн дагуу, бүх банкны ТУЗ гурваас доошгүй хараат бус гишүүнтэй байхыг шаардана. Мөн ТУЗ-ийн шинэ гишүүний томилгоо нь МБ-наас зөвшөөрсний дараа хүчин төгөлдөр болно (өмнө нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгосноор хүчин төгөлдөр болж байсан).

Дээр дурдсан гурваас доошгүй хараат бус гишүүнтэй байх шаардлага зөвхөн “системийн банкинд” хамаарч, системийн бус банк ТУЗ-даа есөөс доош гишүүнтэй, түүний нэг нь хараат бус гишүүн байхыг зөвшөөрч байсан. Ийнхүү Нэмэлт, Өөрчлөлт батлагдсанаар системийн бус банкуудын ТУЗ есөөс доошгүй гишүүнтэй, үүнээс гуравны нэгээс дээш нь хараат бус гишүүн байх шаардлагатай болж байна.

VI. “Системийн банк”-ны хувь нийлүүлсэн хөрөнгөд тавих шаардлага

Нэмэлт, Өөрчлөлтийн дагуу, “системийн банк”-ны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ бусад банктай харьцуулахад нэмэгдэж болзошгүй байна. Тодруулбал, “системийн банк”-ны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг МБ-наас тогтооно.

Өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөж буй журмын дагуу, “системийн” эсэхээс үл хамааран бүх банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 50 тэрбум төгрөг (ойролцоогоор 17,5 сая ам.доллар) бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 100 тэрбум төгрөг (ойролцоогоор 35,0 сая ам.доллар) болон нэмэгдэхээр байна.

Үндсэн Шаардлагуудыг хангах үүднээс, Нэмэлт, Өөрчлөлтийн дагуу МБ-наас “системийн банк”-ны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг (одоо), эсхүл 100 тэрбум төгрөгөөс (2022 оны 1 сарын 01-ний өдрөөс мөрдөгдөх) өндөр байх шаардлага тогтоож болзошгүй байна.

VII. Төлбөр барагдуулах дараалал

Нэмэлт, Өөрчлөлтөд зааснаар, банкныг татан буулгахад дор дурдсан дарааллаар банкны үүрэг гүйцэтгүүлэгчдийн төлбөрийг барагдуулна. Үүнд:

- 1) Бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах тухай шүүхийн шийдвэрийг үндэслэн тухайн банкнаас гаргуулах төлбөр;
- 2) Банкны эрх бүхий албан тушаалтнаас бусад ажилтнуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй цалин хөлс;
- 3) Эрх хүлээн авагчийн үйл ажиллагааны зардал;
- 4) Хадгаламжийн даатгалын корпорацийн хадгаламжийн даатгалд хамаарахгүй иргэдийн хадгаламжийн төлбөр;
- 5) Иргэдийн харилцах дансны төлбөр;
- 6) Хадгаламжийн даатгалын корпорацийн хадгаламжийн даатгалд хамаарахгүй хуулийн этгээдийн хадгаламжийн төлбөр;
- 7) Хуулийн этгээдийн харилцах дансны төлбөр;
- 8) Даатгагдсан хадгаламж эзэмшигчийн шаардах эрхийг шилжүүлсэн авсан Хадгаламжийн даатгалын корпорацийн шаардлага;
- 9) Доорх хадгаламж эзэмшигчийн шаардлага: банкнууд, засгийн газрын агентлагууд, засгийн газрын нийгмийн даатгалын сан;
- 10) Хадгаламжийн даатгалын сангийн шаардлага (засгийн газрын тусгай сан);
- 11) Засгийн газарт төлөх өр төлбөр, албан татвар;
- 12) МБ-ны шаардах эрх бүхий төлбөрийн шаардлага;
- 13) Доорх хадгаламж эзэмшигчийн шаардлага (хамааралтай этгээд, даатгалын тохиолдол бий болохоос өмнөх сүүлийн 3 жилд банкинд аудит хийсэн аудитор, МБ-ны хяналтад үндэслэсэн, банкны санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлсөн, банкны санхүүгийн үйлчилгээнээс илүү ашиг хүртсэн хадгаламж эзэмшигч г.м);

- 14) Банкны бусад өр төлбөрийн дарааллаас дээгүүр байхаар заасан зээл, түүнтэй адилтгах өр төлбөр;
- 15) Зээл, өр төлбөр; болон
- 16) Хоёрдогч өглөг.

Төлбөр барагдуулах дараалалд орсон гол өөрчлөлт нь санхүүгийн хэрэглэгчдийн, тэр дундаа хадгаламж эзэмшигч иргэдийн төлбөрийг банкны хувьцаа эзэмшигчдийн төлбөрөөс өмнө барагдуулахаар заасан байна.

VIII. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид хамаарах шаардлага

Өмнөх зохицуулалтаар, “нөлөө бүхий” хувьцаа эзэмшигч гэж банкны хувьцааны тав ба түүнээс дээш хувийг дангаар, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж буй этгээд, эсхүл банкны бодлого, шийдвэр болон удирдлагад нөлөөлөхүйц хувьцаа эзэмшигчийг үзэж байсан. Нэмэлт, Өөрчлөлтөөр энэхүү тодорхойлолтыг өргөжүүлж, тухайн этгээд, эсхүл хувьцаа эзэмшигчийн “эцсийн өмчлөгч хүн”-ийг хамааруулахаар заасан. Энэ нь 2013 онд батлагдсан Мөнгө Угаах болон Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх тухай хууль дахь “эцсийн өмчлөгч”-ийн тодорхойлолттой нийцүүлэх үүднээс ийнхүү тодорхойлсон гэж ойлгож байна. Нөгөө талаас, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгийн биржид хувьцаа нь арилждаг нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьд энэхүү ойлголтыг хэрхэн хэрэгжүүлэх тухай асуудал нээлттэй үлдэж байна.

Нэмэлт, Өөрчлөлтөд заасан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид хамаарах өөр нэг шинэ шаардлага нь нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч этгээд “төрийн өндөр албан тушаалтан бус” байхаар заасан. “Төрийн өндөр албан тушаалтан”-д Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-н гишүүд, Монгол Улсын Ерөнхий сайд, сайд, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, УДШ-ийн шүүгч, Ерөнхий прокурор, Нийслэлийн болон аймгийн Засаг дарга, Нийслэлийн болон аймгийн ИТХ-ын дарга, МБ болон СЗХ-ны удирдлага зэрэг хамаарна (Монгол Улсын Их Хурлын 2019 оны 19 дүгээр тогтоол).

IX. Бусдын нэрийг ашиглан банкны хувьцааг эзэмшихийг хориглох

Нэмэлт, Өөрчлөлтөөр бусдын нэрийг ашиглан банкны хувьцааг шууд бус хэлбэрээр эзэмшихийг хориглосон. Энэхүү хориглолт нь банкны нийт хувьцааны хориос дээш хувийг эзэмших хүсэлтэй шинэ хувьцаа эзэмшигч (Үндсэн Шаардлага 2-г зөрчин), эсхүл Үндсэн Шаардлага 2-г зөрчиж буй одоогийн хувьцаа эзэмшигч нь хорин хувиас илүү хувьцаагаа өөрийн холбогдох этгээдэд шилжүүлэх нөхцөлд чиглэсэн гэж ойлгож байгаа боловч нөгөө талаас траст, эсхүл үүнтэй ижил төстэй харилцаанд үйлчлэхгүй гэж бид ойлгож байна (тухайлбал, номиналь эзэмшигч, эсхүл кастодиан).

Х. Банкны хувьцааг барьцаалахыг хориглох

Нэмэлт, Өөрчлөлтийн дагуу банкны хувьцааг барьцаалахыг хориглосон байна (жишээлбэл, хувьцаа эзэмшигчийн зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахаар).

ДҮГНЭЛТ

- Нэмэлт, Өөрчлөлт батлагдсанаар, Монгол Улсын банк, үнэт цаасны зах зээлийн салбар төдийгүй, нийт эдийн засагт томоохон өөрчлөлтийн эхлэлийг тавихаар байна.
 - Арилжааны банкнууд нээлттэй хувьцаат компани болсноор (Үндсэн Шаардлага 1) компанийн сайн засаглал, ил тод байдлыг сайжруулах боломжтой болно. Өнөөдрийн байдлаар манай улсад үйл ажиллагаа явуулж буй 12 арилжааны банк бүгд “хязгаарлагдмал хариуцлагатай компани” буюу хаалттай компаниуд бөгөөд тэдгээрийн хувьцааны өмчлөл, цаашлаад банкны менежмент, шийдвэр гаргалт цөөн хэдэн хувьцаа эзэмшигчдийн гарт төвлөрсөн байдаг.⁸ Нэмэлт, Өөрчлөлтийн үр дүнд зарим банкныг олон нийтэд нээлттэй (Үндсэн Шаардлага 1) болгохоос гадна тэдний хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах нь зүйтэй (Үндсэн Шаардлага 2). Олон нийтээс шинэ хувьцаа эзэмшигчид банкинд орж ирснээр тухайн банкны
-

⁸ 2020 оны 11 дүгээр сарын сүүлийн байдлаар, банкны секторын нийт хөрөнгө 35.8 их наяд төгрөг байсан бөгөөд түүний 10 орчим хувь нь эздийн өмч байна (эх сурвалж: МБ).

өмчлөл болон менежментийг салгах боломж бүрдэнэ. Мөн үнэт цаасны зах зээлийг зохицуулсан дүрэм, журмын дагуу илүү ил тод байдал, тайлагнал шаардагдана. Арилжааны банкнуудын үйл ажиллагаанд МБ-наас гадна СЗХ, МХБ нар тус бүрийн чиглэлээр хяналтыг тавина.

- Нэмэлт, Өөрчлөлтийн үр дүнд банкны салбар дахь нэгдэх, нийлэх үйл явц эрчимжих магадлалтай байна⁹.
- Үндсэн Шаардлага 1-г зохих журмын дагуу хэрэгжүүлснээр одоогийн үнэт цаасны зах зээлийн үнэлгээний хэмжээ хоёр дахин нэмэгдэж, шинэ хөрөнгө оруулагчдын анхаарлыг татах боломжтой. Ингэснээр Монгол Улсын үнэт цаасны жижиг зах зээлийн хөгжилд түлхэц болох боломж гарч ирж байна. Түүнчлэн манай орны үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтын орчны шинэчлэл, өрсөлдөөн, зах зээлийн оролцогч болон зохицуулагчдын чадавхийг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй юм.
- Нөгөө талаас, Нэмэлт, Өөрчлөлтийг зөв, цаг тухайд хэрэгжүүлэх асуудал чухал юм. Үндсэн Шаардлагуудыг, ялангуяа Үндсэн Шаардлага 1-г заасан хугацаанд бүрэн дүүрэн хангах явдал эргэлзээ төрүүлж байна. Хуульд шахуу хугацаа зааснаас гадна гадны хүчин зүйлс, тухайлбал, хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны зах зээл дээрх бусад мэргэжлийн оролцогчдын дутагдал, хөрөнгө оруулагчдын тоо, чадамж, бэл бэнчингийн хязгаарлагдмал байдал, хувьцааны үнийг бодитой тогтоох, талууд хүлээн зөвшөөрөх, одоогийн үнэт

⁹ 2021 оны 1 дүгээр сарын байдлаар 12 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс Худалдаа, Хөгжлийн Банк болон Улаанбаатар Хотын Банк 2020 онд нэгдсэн. Үүний нэг шалтгаан нь нэг хувьцаа эзэмшигч хоёр, түүнээс дээш банкинд зэрэг хувьцаа эзэмшихийг хориглосон хуулийн заалт байсан. Энэхүү нэгдлээс гадна зарим жижиг банкнууд нэгдэхээр яриа хэлэлцээр хийж байгаа тухай мэдээлэл байна.

цаасны зах зээлийн дэд бүтэц, техникийн чадавх, манай орны улс төр, бодлого зохицуулалтын зарим тодорхойгүй байдал, цар тахлын урт хугацааны нөлөөлөл, 2021-2024 онд хийгдэх Монгол Улсын Засгийн газрын бондын эргэн төлөлт зэрэг нь Үндсэн Шаардлагуудыг бүрэн, цаг тухайд нь хэрэгжүүлэх ажлыг хойшлуулах, эсхүл үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагад хүргэж болзошгүй юм. Эдгээр нь банкнуудыг зохистой харьцааны шалгууруудыг хангахгүйд хүргэх эрсдэлтэй байж болох юм.

- Дотоодын хөрөнгө оруулагчдын санхүүгийн дутмаг байдлаас үүдэн банкнуудын хувьцааг гадаадын зарим орны хөрөнгө оруулагчид их хэмжээгээр худалдаж авч, хууль тогтоогчийн хүсээгүй үр дагаварт хүргэхгүйн тулд Үндсэн Шаардлагуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн болгоомжтой хандах нь зүйтэй болов уу.
- Мөн Үндсэн Шаардлагууд, ялангуяа Үндсэн Шаардлага 2 нь банкны одоогийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны хэмжээг хүчээр багасгахыг шаардаж байгаа нь тэдний Үндсэн хуульд заасан эрхэд нь харшилж байна гэх байр суурь байхыг үгүйсгэхгүй.
- Иймд Нэмэлт, Өөрчлөлтийн хэрэгжилт нь 2018 онд УИХ-аас баталсан Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн нэгэн адил учир дутагдалтай байж болзошгүй байна. (Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулиар ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн активын чанарын үнэлгээний үр дүнд зарим “системийн” банкныг

дахин хөрөнгөжүүлэх зорилгоор 2018 онд батлагдсан боловч тус хуулийн зорилт биелсэн эсэх нь тодорхойгүй байна)¹⁰.

- Мөн банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг хориглох (Үндсэн Шаардлага 2), олон нийтэд нээлттэй болгохын (Үндсэн Шаардлага 1) аль аль нь банкны сайн засаглал, өрсөлдөөнт банкны салбар, үнэт цаасны зах зээлийн бодит хөгжлийн баталгаа биш юм¹¹.
- Нэмэлт, Өөрчлөлт, түүнд заасан Үндсэн Шаардлагуудыг зөв хэрэгжүүлэх эсэх нь МБ, СЗХ-ны чадавхаас хамаарна. Иймд нэмэлт боловсон хүчнээс гадна МБ, СЗХ, бусад байгууллагуудын Нэмэлт, Өөрчлөлт, түүнд заасан Үндсэн Шаардлагуудыг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх, мөрдүүлэх ур чадвар, чадавхийг бэхжүүлэх нь зүйтэй.
- Монгол Улсын хувьд өөр нэг чухал асуудал нь Үндсэн Шаардлагуудыг хэрэгжүүлэх МБ, СЗХ-ны улс төрийн хүсэл зориг, шийдэмгий байдал юм.
- Монгол Улсын үнэт цаасны зах зээлд холбогдох одоогийн дүрэм, журам нь банкнуудыг нээлттэй ХК болгоход тэр бүр хангалттай зохицуулалтыг агуулаагүй. МБ, СЗХ-ноос батлах журмаар Үндсэн Шаардлагуудыг хэрэгжүүлэхэд хууль зүй, бодлого зохицуулалтын дараах асуудлуудыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

¹⁰ Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн талаарх мэдээллийг дараах хаягаар үзэх боломжтой: www.khanlex.mn/wp-content/uploads/2020/12/BankingLaw-Aug-2018.pdf.

¹¹ Жич: одоогоор нийт 12 арилжааны банкаас Хасбанкны холдинг компани нь нэг хувьцаа эзэмшигчийн 20 хувийн хязгаарлалтыг хангаж буй бөгөөд Үндсэн Шаардлага 2 нь Хасбанкны холдинг компанид хамаарахгүй гэж үзэж байна.

- Банкны хувьцаа, бусад үнэт цаасыг хэрхэн бүртгэх (жишээлбэл, хувьцаа эзэмшигчдийн тооны доод хязгаар, хувьцааг нийтэд санал болгох арга – тухайлбал, хаалттай захиалгыг зөвшөөрөх эсэх г.м),
- Банкны хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа,
- Банк нэгдэх, нийлэх, тусгаарлах журам (жишээлбэл, шинэ хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, хяналтын өөрчлөлтийг – “change of control” - хэрхэн хянах, зөвшөөрөх, Үндсэн Шаардлага 2-г хангахын тулд нэг хувьцаа эзэмшигчийн хувь эзэмшлийн хэмжээг 20% болгон бууруулахад тавих шаардлага, журам, татвар, нягтлан бодох бүртгэлийн асуудлууд г.м),
- Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрхэн хангах,
- Тайлагналын болон ил тод байдлын шаардлагууд,
- Хөрөнгө оруулалт, хувьцаа эзэмшигчид тавих шаардлагууд,
- Нээлттэй банкнуудын хөрөнгийн болон бусад зохистой харьцаа г.м.¹²

¹² Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу, үнэт цаас гаргагч IPO хийхэд дараах шаардлагыг хангасан байна:

- Нийт хувьцааны олон нийтэд санал болгох хувь 25%-иас доошгүй байх. Үнэт цаас гаргагч нь IPO гаргах үеэр "стратегийн хөрөнгө оруулагчид" тухайн үнэт цаасны 50 хүртэл %-ийг санал болгох боломжтой. Иймд Монгол Улсын одоогийн мөрдөж буй журмын дагуу IPO гаргахад нийтэд болгох үнэт цаасны хэмжээ ойролцоогоор 12,5% байна;
- Хөрөнгийн биржэд бүртгэлтэй компанийн хагас жилийн арилжааны дүн нь тухайн хугацаанд МХБ-ийн нийт арилжааны үнийн дүнгийн 5% -иас дээш байх ёстой;
- 100-аас дээш хувьцаа эзэмшигчтэй байх;
- Хувьцаа нь аливаа барьцаа, батлан даалт зэрэг үүргийн гүйцэтгэлийг хангах аргаас ангид байх;
- Тухайн компанийн зах зээлийн үнэлгээ 10 тэрбум төгрөгөөс (ойролцоогоор 3,5 сая ам.доллар) дээш байх;
- Орлого болон ашгийн төвшний доод хязгаар мөн тавигддаг. Үнэт цаас гаргагч компани нь тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд дээрх бүх шаардлагуудаас, эсхүл аль нэгнээс чөлөөлөгдөх хүсэлтийг МХБ-нд гаргаж болно.

- Үүнээс гадна, Үндсэн Шаардлага 1-тэй холбоотойгоор Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй банк нь гадаадын хөрөнгийн биржид хувьцаагаа бүртгүүлж болох эсэхийг мөн зохицуулах шаардлагатай. Хэдийгээр хууль санаачлагчийн зорилго нь банкуудаар дамжуулан дотоодын үнэт цаасны зах зээлийг дэмжих явдал байж болох ч Нэмэлт, Өөрчлөлтөд банкнууд зөвхөн МХБ-нд хувьцаагаа бүртгүүлэх, арилжих ёстой гэж шууд заагаагүй. Иймд банкнууд гадаадын хөрөнгийн биржид хувьцаа гаргах эсэхийг өөрсдөө сонгох боломжтой гэж дүгнэж болохоор байна. Түүнчлэн, хувьцааг нийтэд гаргахыг зөвхөн МХБ-ээр хязгаарласан ч үнэт цаас гаргагч банк нь эхлээд МХБ-нд үнэт цаасаар гаргагчаар бүртгүүлж, улмаар гадаадын хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй байх боломжтой гэж бид ойлгож байна¹³.
- Эцэст нь дурдахад, Үндсэн Шаардлагуудаас гадна, Банкны тухай хуульд оруулсан бусад нэмэлт, өөрчлөлтийг буцаан хэрэглэхгүй гэж ойлгож байна. Нэмэлт, Өөрчлөлтөд зааснаар банкны хувьцааг гуравдагч этгээдэд (зээл олгогчид) барьцаалахыг хориглосон нь Нэмэлт, Өөрчлөлт батлагдахаас өмнө хүчин төгөлдөр болсон хувьцааны барьцааны хүчин төгөлдөр, албадан биелэгдэх шинжид нөлөөлөхгүй гэж үзэж байна.

¹³Монгол Улсын хувьд үнэт цаас гаргагчийн хувьцааг МХБ, гадаадын хөрөнгийн биржид давхар бүртгэхийг зөвшөөрсөн холбогдох дүрэм, журмыг саяхан баталсан байдаг. Эдгээр дүрэм, журмын хүрээнд үнэт цаас гаргагч нь гадаадад хоёрдогч бүртгэлийг хийх боломжтой. Үнэт цаас гаргагч нь гадаад улсад хуулийн этгээд байгуулахгүйгээр (тухайн биржийн шаардлагыг хангасан тохиолдолд) гадаадад хувьцааны давхар бүртгэлийг хийх боломжтой болсноор МХБ, гадаадын хөрөнгийн биржийн хувьцаа хоорондын хөрвөх чадвар (fungibility)-ыг хангах боломжийг бүрдүүлсэн. Одоогоор манай улсад үнэт цаас гаргагч гадаадын хөрөнгийн биржид давхар бүртгэл хийлгэсэн тохиолдол байхгүй байгааг дурдах нь зүйтэй юм.

Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаар авна уу:



Хуульч Б.Энхбат



+976-99111061



EnkhbatB@khanlex.mn



Хуульч Б.Хулан



+976-80227704



khulan@khanlex.mn

САНАМЖ:

Өмгөөллийн ХаанЛекс Партнерс ХХН нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд (2012 он) заасны дагуу үүсгэн байгуулагдаж, Монгол Улсын хуулийн асуудлаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл юм.

Энэхүү нийтлэлд түүнд агуулагдаж буй мэдээлэлд хамаарах үндсэн, чухал асуудлыг дурдаагүй байж болох бөгөөд гагцхүү үйлчлүүлэгч болон сонирхогч этгээдэд ерөнхий мэдээлэл өгөх зорилгоор бэлтгэсэн болно. Энэхүү нийтлэлийг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд өгсөн эрх зүйн зөвлөх үйлчилгээ гэж үзэхгүй болно.

*2021 оны 3 дугаар сарын 09-ний өдөр
Англи хэлнээс орчуулав.*



©KhanLex Partners LLP

Манай хаяг:

Монгол Улс, Улаанбаатар 14240,
Сүхбаатар дүүрэг, Олимпын гудамж-5,
Аюуд Тауэр, XIV давхар, 1404 тоот

Утас: (+976) 7747-1122

info@khanlex.mn

www.khanlex.mn